3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Булган сумын Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Булган сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх үр дагавартай байна.

Байгууллагын дотоод хяналтаар 2020 онд харьяа 1, 2, 6-р цэцэрлэгүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 5 зөвлөмж өгсөн байна. Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож ажилласан байна. Харин санхүүгийн хяналт аудитын албанаас харьяа байгууллагуудад дотоод аудит хийгээгүй байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн батлагдсан төсвийн 15,031.1 сая төгрөгийн 1 хувь буюу 150.3 сая төгрөгөөр тогтоов. Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 213.1 сая, эцсийн үлдэгдэл 268.3 сая төгрөг болж, 55.2 сая төгрөгөөр буюу 25.9 хувиар өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	213.1	266.0	52.9	99.1
Арилжааны банкин дахь харилцах	0.03	1.6	1.6	0.6
Бусад төсөл нөөцийн харилцах		0.7	0.7	0.3
Дүн	213.1	268.3	55.2	100
Үүнээс байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага		0.7	0.7	0.3
Төсөл/сан	129.6	177.9	48.3	66.3
Төрийн сан	83.5	88.1	4.6	32.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	0.03	1.6	1.6	0.6
Дүн	213.1	268.3	55.2	100.0

Эх сурвалж: Булган сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 266.0 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 1.6 сая төгрөг арилжааны банкны дансанд, 0.7 сая төгрөг бусад төсөл нөөцийн харилцах дансанд тус тус байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Тухайлбал: Эмийн цэцэглэн өрхийн эрүүл мэндийн төв 0.1 сая, ЗДТГ 1.3 сая төгрөг.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 1,008.6 сая, эцсийн үлдэгдэл 1,017.1 сая төгрөг болж 8.5 сая төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	1.7	0.7	(1.0)	0.1
Байгууллагаас авах авлага	102.6	140.8	38.2	13.8

Хувь хүнээс авах авлага	904.3	875.6	(28.7)	86.1
Дүн	1,008.6	1,017.1	8.5	100.0
Үүнээс байгууллагын төрлөөр				
Соёлын төв	-	1.1	1.1	0.1
Булган сумын 3-р сургууль	0.3	-	(0.3)	-
Булган сумын 1-р сургууль	-	0.03	0.03	-
Булган сумын 1-р цэцэрлэг	-	9.0	9.0	0.9
Булган сумын 2-р цэцэрлэг	-	17.1	17.1	1.7
Булган сумын 3-р цэцэрлэг	0.5	3.2	3.2	0.3
Булган сумын 4-р цэцэрлэг	0.2	7.0	6.8	0.7
Булган сумын 6-р цэцэрлэг	-	7.5	7.5	0.7
Булган сумын 7-р цэцэрлэг	1.4	10.6	9.2	1.0
Эмийн цэцэглэн өрхийн ЭМТ	-	0.7	0.7	0.1
Сум дундын ойн анги	2.4	-	(2.4)	-
Сум хөгжүүлэх сан	1,003.8	960.8	43.0	94.5
Дүн	1,008.6	1,017.1	8.5	100.0

Эх сурвалж: Булган сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансанд олон жилийн насжилттай сум хөгжүүлэх сангийн 53 зээлдэгчийн 236.4 сая төгрөгийн авлага байна. Эдгээр нь жижиг дунд үйлдвэрлэл хөгжихгүй, ажлын байр нэмэгдэхгүй, зээлийн эргэлт удаашрах үр дагавартай байна.

Аудитын илрүүлэлт:

- Хүүхдийн тоглоом худалдах, худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй бараа бүтээгдэхүүнээ хугацаандаа аваагүйгээс, төсвийн шууд захирагч төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй авлага үүсгэж, харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна. Тухайлбал: Булган сумын 1, 2, 3, 4, 5, 6, 7-р цэцэрлэгүүдийн 39.1 сая, Эмийн цэцэглэн өрхийн ЭМТ 1.7 сая төгрөг.
- Булган сумын ойн анги өмнөх онд 5.9 сая төгрөгийн авлагыг тайланд тайлагнаагүй.
- Харьяа байгууллагуудын тайлант онд үүссэн авлагаас сургуулийн өмнөх боловсролын байгууллагын авлага 96.6 хувийг эзэлж байгаа нь сумын Засаг дарга Төсвийн тухай хуулийн 39.4.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 878.5 сая, эцсийн үлдэгдэл 838.4 сая төгрөг болж, 68.1 сая төгрөгөөр буюу 4.6 хувиар буурсан байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эдлэх хувь
Тусгай зориулалтын материал	238.2	116.3	(121.9)	13.9
Эм боох материал	6.4	21.9	15.5	7.8
Бичиг хэргийн материал	10.6	12.7	2.1	1.5
Аж ахуйн материал	281.7	359.5	77.8	42.9
Сэлбэг хэрэгсэл	37.6	42.1	4.5	5.0
Түлш шатах тослох материал	14.0	8.0	(6.0)	0.9
Барилгын засварын материал	22.6	28.9	6.3	3.4
Хүнсний материал	62.3	28.9	(33.4)	3.4
Бусад хангамжийн материал	191.9	181.2	(10.7)	21.6
Мал амьтад	13.1	10.8	(2.3)	1.3
Тэжээлийн нөөц	-	25.2	(25.2)	3.0
Бусад нөөц	-	2.8	2.8	0.3
Дүн	878.5	838.4	(40.1)	100.0
Үүнээс байгууллагын төрлөөр				
Сумын ЗДТГ	127.6	53.8	(53.70)	6.4
Сумын ИТХ	1.7	1.5	(0.2)	0.2
Соёлын төв	21.9	19.1	(2.8)	2.3
Эрдмийн өргөө цогцолбор сургууль	84.4	98.8	14.4	11.8
Булган сумын 3-р сургууль	42.1	60.3	18.3	7.2

Булган сумын 1-р сургууль	139.8	106.4	(33.4)	12.7
Булган сумын 1-р цэцэрлэг	41.9	42.3	0.4	5.0
Спортын дунд сургууль	33.5	42.0	8.5	5.0
Булган сумын 2-р цэцэрлэг	76.8	68.8	(8.0)	8.2
Булган сумын 3-р цэцэрлэг	37.6	43.5	5.9	5.2
Булган сумын 4-р цэцэрлэг	39.6	47.0	7.4	5.6
Булган сумын 6-р цэцэрлэг	44.8	36.9	(7.9)	4.4
Булган сумын 7-р цэцэрлэг	62.1	67.3	5.2	8.0
Цоожид өрхийн ЭМТ	20.8	25.5	4.7	3.0
Эмийн цэцэглэн өрхийн ЭМТ	19.6	30.1	10.5	3.6
Сум дундын ойн анги	11.5	10.0	(1.5)	1.2
Сум хөгжүүлэх сан	0.1	0.1	-	-
Хот тохижилт үйлчилгээний газар	67.9	70.0	2.1	8.4
Насан туршийн боловсролын төв	4.8	15.0	10.2	1.8
Дүн	878.5	838.4	(40.1)	100.0

Эх сурвалж: Булган сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 682.7 сая, хандиваар 6.4 сая, данс хооронд болон балансаас балансын хооронд шилжүүлэн авсан 100.9 сая, малын нас дэвшилтээс 3.7 сая төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 621.2 сая, шилжүүлсэн 175.1 сая, малын нас дэвшилт болон акталсан 57.7 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

Бараа материалын тайлангийн үлдэгдэлд тайлант оны эцэст 102.5 сая төгрөгийн тусгай зориулалтын материал, бичиг хэрэг, аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, барилгын засварын материал, бусад хангамжийн материалыг төсвийн хэмнэлтийг улс, орон нутгийн буцаан төсөвт төвлөрүүлэхгүй шалтгаанаар нөөцөлсөн байна. /ЗДТГазар 21.0 сая, өрхийн ЭМТ 9.2 сая, насан туршийн боловсрол 1.9 сая, 3-р сургууль 13.9 сая, 7-р цэцэрлэг 8.1 сая, 4-р цэцэрлэг 6.7 сая, 1-р цэцэрлэг 9.2 сая, Эрдмийн өргөө цогцолбор сургууль 14.5 сая, 6-р цэцэрлэг 3.2 сая, 3-р цэцэрлэг 3.4 сая, спортын дунд сургууль 11.6 сая төгрөг/

Аудитын илрүүлэлт:

- УСНББОУС-12 хэрэгжүүлээгүй бараа материал тайлангийн дансны ангиллыг буруу бүртгэсэн байна. Тухайлбал: ЕБС-ын 1-р сургууль 4.7 сая, 6-р цэцэрлэг 14.1 сая, 2-р цэцэрлэг 50.5 сая төгрөг, 7-р цэцэрлэг 0.7 сая, 3-р цэцэрлэг 1.1 сая төгрөг байна.
- Бараа материалын тайлангийн дансны үлдэгдэл тус бүрээр тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй. Тухайлбал: Булган 1, 2, 6, 7-р цэцэрлэг 214.5 сая төгрөг.
- Бараа материалыг тайлан гаргаагүй. Эмийн цэцэглэн, Цоодид өрхийн ЭМТ.
- ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлээгүй тендер сонгон шалгаруулалтаар эм эмнэлэгийн хэрэгсэл нийлүүлэгчээр шалгараагүй компаниас эм, эмнэлэгийн хэрэгслийг худалдан авсан. Тухайлбал: Эмийн цэцэглэн өрхийн ЭМТ.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 20,405.5 сая, эцсийн үлдэгдэл 19,389.6 сая төгрөг болж 1,015.9 сая төгрөгөөр буюу 4.9 хувиар буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Барилга байгууламж, орон сууц	20,405.5	19,392.2	(1,013.3)	66.8
Хуримтлагдсан элэгдэл	(2,882.6)	(1,504.8)	(1,380.5)	(5.2)
Авто-тээврийн хэрэгсэл	801.1	791.1	(10.0)	2.7
Хуримтлагдсан элэгдэл	342.1	312.0	30.1	(1.1)
Машин тоног төхөөрөмж/компьютер/	2,399.9	2,296.8	(37.2)	7.9
Хуримтлагдсан элэгдэл	(1,093.4)	(598.2)	495.2	(2.1)
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,201.9	1,149.6	(52.3)	4.0
Хуримтлагдсан элэгдэл	(795.4)	(599.0)	196.4	(2.1)
Зам, гүүрийн байгууламж	3,265.9	3,306.6	40.4	11.4
Хуримтлагдсан элэгдэл	(504.6)	(540.3)	(35.6)	(1.9)

Батлан хамгаалах, цэргийн зориулалттай т.төхөөрөмж	0.4	0.4	-	-
Хуримтлагдсан элэгдэл	(0.2)	(0.2)	-	-
Түүх соёл, музейн дурсгалт зүйл	591.6	591.6	-	2.0
Бусад үндсэн хөрөнгө	3,188.1	3,143.4	(44.7)	10.8
Хуримтлагдсан элэгдэл	(834.7)	(861.3)	(26.5)	(3.0)
Дуусаагүй барилга, байгууламж	1,340.3	-	(1,340.3)	-
Ном	145.6	87.7	(57.9)	0.3
Программ хангамж	22.3	24.9	2.5	0.1
Хуримтлагдсан элэгдэл	(18.8)	(6.1)	12.7	-
Бусад биет бус хөрөнгө	2,653.3	2,654.6	1.3	9.1
Дүн	29,477.9	29,016.5	(461.4)	100.0
Сумын ЗДТГ	3,105.0	3,166.7	61.6	10.9
Сумын ИТХ	4.6	5.1	0.5	-
Соёлын төв	1,162.4	1,143.1	(19.3)	3.9
Эрдмийн өргөө цогцолбор сургууль	1,669.7	2,119.3	449.6	7.3
Булган сумын 3-р сургууль	4,332.5	4,314.5	(18.0)	14.9
Булган сумын 1-р сургууль	5,922.6	5,289.8	(632.8)	18.2
Булган сумын 1-р цэцэрлэг	610.1	602.8	(7.3)	2.1
Спортын дунд сургууль	1,128.4	1,105.2	(23.2)	3.8
Булган сумын 2-р цэцэрлэг	1,625.0	1,462.2	(262.8)	4.7
Булган сумын 3-р цэцэрлэг	99.3	115.0	15.6	0.4
Булган сумын 4-р цэцэрлэг	176.9	160.6	(16.3)	0.6
Булган сумын 6-р цэцэрлэг	443.8	444.7	0.9	1.5
Булган сумын 7-р цэцэрлэг	441.0	433.1	7.9	1.5
Цоожид өрхийн ЭМТ	59.1	179.1	120.0	0.6
Эмийн цэцэглэн өрхийн ЭМТ	149.5	82.1	(67.4)	0.3
Сум дундын ойн анги	50.9	41.6	(9.3)	0.1
Сум хөгжүүлэх сан	0.1	0.7	(0.2)	-
Насан туршийн боловсрол	12.5	16.9	4.4	0.1
Тохижилт үйлчилгээний анги	8,483.5	8,434.0	(49.5)	29.1
Дүн	29,477.9	29,016.5	(461.4)	100.0

Эх сурвалж: Булган сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 199.2 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 107.2 сая, анхны өртөгөө элэгдлээрээ нөхсөн хөрөнгийг дахин шинэчлэн үнэ тогтоосон 101.9 сая, данс хооронд шилжүүлсэн, дээд шатны төсвийн захирагчаас хийгдсэн хөрөнгө оруулалт 2,258.0 сая, үнэ төлбөргүй буюу хандиваар авсан 236.2 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас балансад шилжүүлсэн 65.5 сая, акталсан 3,153.1 сая, үлдэгдэх өртөг нь дуусаагүй хөрөнгийг данснаас хассанаас үүссэн дахин үнэлгээний хорогдол 210.4 сая, дуусаагүй барилга дансны үлдэгдлийг барилга байгууламжийн дансруу шилжүүлснээс 1,987.5 сая төгрөгөөр тус тус хасагдснаас шалтгаалжээ.

Дуусаагүй барилга дансанд 1,340.3 сая төгрөгийн 2-р цэцэрлэгийн шинэ барилгыг улсын комисс хүлээн авч барилга байгууламж дансанд шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- *УСНББОУС-17 хэрэгжүүлээгүй үндсэн хөрөнгийн тайлангийн дансны ангиллыг буруу бүртгэсэн байна. Тухайлбал: Булган сумын 3, 7, 2, 6-р цэцэрлэг, ЕБС-ын 3-р сургууль 4,202.9 сая төгрөг.*
- *Үндсэн хөрөнгийн тайлангийн дансны үлдэгдэл тус бүрээр тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй. Тухайлбал: Булган сумын 1, 2, 6, 7-р цэцэрлэг.*
- *Машин тоног төхөөрөмжийн дансны зарим нэр төрлийн хөрөнгийн ашиглалтын хугацааг буруу тооцоо тооцсон, анхны өртөгөөрөө элэгдэлээрээ бүрэн нөхсөн хөрөнгийг шинэчлэн үнэ тогтоогоогүй хөрөнгүүд байна. Тухайлбал: ЕБС-ын 1-р сургууль 39.5 сая төгрөг.*
- *Хөрөнгө бэлтгэх шийдвэр, зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна. Тухайлбал: Цоожид, Эмийн цэцэглэн өрхийн ЭМТ 24.3 сая төгрөг.*

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 8.1 сая, эцсийн үлдэгдэл 9.8 сая төгрөг болж 1.7 сая төгрөгөөр буюу 20.9 хувиар өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	/сая төгрөг/
				Дүнд эзлэх хувь
Ажиллагсадтай холбогдсон өглөг	1.2	4.9	3.7	48.5
Байгууллагад төлөх өглөг	6.2	3.8	2.4	37.7
Хувь хүмүүст төлөх өглөг	0.7	0.9	0.2	8.9
Татварын өглөг /ТӨҮГ/	-	0.5	0.5	4.9
Дүн	8.1	10.1	2.0	100.0
Соёлын төв	1.0	1.1	0.1	11.2
Булган сумын 3-р сургууль	3.9	-	(3.9)	-
Булган сумын 3-р цэцэрлэг	-	0.2	0.2	2.0
Булган сумын 4-р цэцэрлэг	0.6	3.7	3.1	37.8
Булган сумын 7-р цэцэрлэг	0.2	0.8	1.5	8.2
Эмийн цэцэглэн өрхийн ЭМТ	-	1.1	0.3	11.2
Цоожид өрхийн ЭМТ	0.7	-	0.3	-
Хот тохижилт үйлчилгээний анги	-	1.2	1.2	12.3
Орон нутгийн ерөнхий орлого	1.7	1.7	-	17.3
Дүн	8.1	9.8	1.7	100.0

Эх сурвалж: Булган сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 3.7 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, 5.2 сая төгрөгийн харилцагч байгууллагад төлөх өр, 0.9 сая төгрөгийн цалингийн өр байна.

Аудитын илрүүлэлт:

- Булган сумын 3-р сургууль өмнөх оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй 0.4 сая төгрөгийг үр дүнгийн урамшууллыг олгосон байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 31,570.0 сая, эцсийн үлдэгдэл 31,130.1 сая төгрөг болж, 439.9 сая төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	/сая төгрөг/
				Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	11,957.8	11,957.8	-	38.4
Хуримтлагдсан үр дүн	10,341.9	9,902.0	(439.9)	31.8
Өмнөх үеийн үр дүн	8,881.8	10,342.1	1,460.3	33.2
Тайлант үеийн үр дүн	1,460.1	(440.1)	(1,900.2)	(1.4)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,270.3	9,270.3	-	29.8
Дүн	31,570.0	31,130.1	(439.9)	100.0
Сумын ЗДТГ	3,232.6	3,220.5	(12.1)	10.3
Сумын ИТХ	6.2	6.6	0.4	0.0
Соёлын төв	1,183.3	1,162.2	(21.1)	3.7
Эрдмийн өргөө цогцолбор сургууль	1,754.1	2,219.0	464.9	7.1
Булган сумын 3-р сургууль	4,370.9	4,374.8	3.9	14.1
Булган сумын 1-р сургууль	6,062.4	5,396.2	(666.2)	17.3
Булган сумын 1-р цэцэрлэг	651.9	654.1	2.2	2.1
Спортын дунд сургууль	1,162.0	1,147.2	(14.8)	3.7
Булган сумын 2-р цэцэрлэг	1,701.9	1,448.1	(253.8)	4.7
Булган сумын 3-р цэцэрлэг	137.4	161.5	24.1	0.5
Булган сумын 4-р цэцэрлэг	216.2	210.9	(5.3)	0.7

Булган сумын 6-р цэцэрлэг	488.6	489.1	0.5	1.6
Булган сумын 7-р цэцэрлэг	504.3	510.1	5.8	1.6
Цоожид өрхийн ЭМТ	79.2	112.7	33.5	0.4
Эмийн цэцэглэн өрхийн ЭМТ	169.1	204.8	35.7	0.7
Сум дундын ойн анги	64.8	51.6	(13.2)	0.2
Насан туршийн боловсрол	17.4	32.0	14.6	0.1
Хот тохижилт үйлчилгээний анги	8,551.4	8,502.8	(48.6)	27.3
Орон нутгийн ерөнхий орлого	81.8	86.3	4.5	0.3
Сум хөгжүүлэх сан	1,119.4	1,128.0	8.6	3.6
Орон нутгийн хөгжлийн сан	15.1	11.6	(3.5)	0.0
ДҮН	31,570.0	31,130.1	(439.9)	100.0

Эх сурвалж: Булган сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 31,130.1 сая төгрөг болж 439.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардал болон ашиглалтын хугацаа дууссан барилга байгууламж акталж данснаас хассанаас шалтгаалжээ. Үүнд:

- Булган сумын 1- р сургуулийн хуучин барилга 2,960.4 сая төгрөг,
- Булган сумын 2- р цэцэрлэгийн хуучин барилга 328.1 сая төгрөг,

Төрийн өмчийн дансны үлдэгдэл 11,957.8 сая төгрөг болж, тайлант онд өөрчлөлт гараагүй байна

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 9,270.3 сая төгрөг болж тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Хуримтлагдсан үр дүн 9,902.8 сая төгрөг болж 439.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүн алдагдалтай тайлагнаснаас шалтгаалжээ.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд Хот тохижилт үйлчилгээний ангийн татварын хэлтэстэй 2019 оны тооцоо нийлсэн актыг үйлдээгүйгээс шалтгаалж, бүртгэгдсэн 0.2 сая төгрөгийн алдааны залруулга байна.

3.5.7 Орлогын данс

Орлогын төлөвлөгөөг 945.1 сая төгрөгөөр баталж, 936.4 сая төгрөгийг бүрдүүлэн, 8.7 сая төгрөгөөр буюу 0.9 хувиар тасалсан байна.

Хүснэгт №7 Орлогын гүйцэтгэл

ЭЗА	Үзүүлэлт	/сая төгрөг/		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт +, хэмнэлт-
1	Урсгал орлого	945.1	936.4	8.7
11	Татварын орлого	642.3	722.1	(79.8)
110	Орлогын албан татвар	455.2	465.3	(10.1)
1100	Хувь хүний орлогын албан татвар	455.2	465.3	(10.1)
110002	Үйл ажиллагааны орлого	52.0	68.9	(16.9)
110003	Хөрөнгийн орлого	207.6	230.9	(23.3)
110008	Шууд бус орлого	195.6	165.4	30.2
113	Хөрөнгийн албан татвар	6.0	3.8	2.2
113002	Бууны албан татвар	6.0	3.8	2.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	181.1	253.1	(72.0)
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	176.2	240.1	(63.9)
118001	Улсын тэмдэгтийн хураамж	95.7	153.7	(58.0)
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	11.0	10.4	0.6
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	68.0	76.0	(7.9)
118011	Бусад татвар	1.5	-	1.5

1181	Газрын төлбөр	-	9.2	(9.2)
118101	Газрын төлбөр	-	9.2	(9.2)
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	4.9	3.8	1.1
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	0.8	1.7	(0.9)
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	4.1	2.1	2.0
12	Татварын бус орлого	262.0	214.3	47.7
120003	Торгуулийн орлого	261.0	210.4	50.6
120009	Бусад орлого	1.0	3.9	(2.9)

Эх сурвалж: Булган сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл үйл ажиллагааны орлого 32.6 хувь, хадгаламжийн хүүгийн орлого 11.2 хувь, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 60.6 хувь, хог хаягдлын хураамжийн орлого 11.6 хувь, гоожингийн орлого 107.0 хувь, бусад орлого 290.0 хувиар тус тус давуулан биелүүлсэн байна.

Суутганы орлого 15.5 хувь, бууны албан татвар 37.1 хувь, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 5.1 хувь, бусад татвар 100 хувь, байгалийн нөөц ашигласны төлбөр 23. Хувь, ус рашаан ашигласны төлбөр 49.0 хувиар тус тус тасарсан байна.

Орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэхэд иргэн бүрт олгож байгаа хувьцааны ногдол ашиг, иргэдийн хадгаламж өссөн, үл хөдлөх хөрөнгө өмнөх жилүүдээс их арилжаалагдснаас нөлөөлсөн байна. Харин орлогын төлөвлөгөө бодитой төлөвлөгдөөгүйгээс шалтгаалан орлого тасарсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Бууны албан татвар 2.2 сая, шууд бус орлого 30.2 сая, түгээмэл тархацтай ашигт малталын төлбөр 0.6 сая, ус рашаан ашигласны төлбөр 2.0 сая төгрөгөөр буюу татварын орлого 34.4 сая төгрөгөөр тасарсан байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 92.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг зөрчсөн байна. Тухайлбал: Булган сумын 3, 7, 2-р цэцэрлэг 17.1 сая, Эмийн цэцэглэн өрхийн эрүүл мэндийн төв 9.1 сая, Цоожид өрхийн эрүүл мэндийн төв 19.4 сая төгрөг
- Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг зөрчин зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг зөрчин батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна. Тухайлбал: Эрдмийн өргөө цогцолбор сургууль, ЕБС-ын 1, 3-р сургууль, 21.3 сая төгрөг, ЗДТГ 0.2 сая, 2-р цэцэрлэг 0.3 сая, Ойн анги 0.1 сая төгрөг.
- Ковид-19 халдварт өвчин гарч Улсын онцгой комиссын шийдвэрээр боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагааг танхимаар хичээлээгүй байхад хөдөлмөрийн дотоод журамд тусгаагдаагүй хоолны мөнгө ажилчдад цалингийн зардлаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал: Эрдмийн өргөө цогцолбор, ЕБС-ын 1, 3-р сургууль, Булган сумын 2, 6, 7-р цэцэрлэг 43.9 сая төгрөг.
- Цалингийн тооцооллыг хууль, журмыг хэрэгжүүлээгүй буруу олгосон. Тухайлбал: Булган сумын 3-р цэцэрлэг 0.2 сая, Цоожид өрхийн эрүүл мэндийн төв 0.3 сая төгрөг.
- СХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан. Тухайлбал: ЗДТГ 8.9 сая төгрөг.
- Сумын ЗДТГ засаг даргын нөөц сангаас 1.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

- УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаагүй тооцоолсон цалингийн зардлыг цалингийн өглөг дансаар дамжуулаагүй, дансны давхар бичилтээр ажил гүйлгээг бүртгээгүй, шууд зардлаар бүртгэсэн байна. Тухайлбал: Булган сумын 6-р цэцэрлэг 3.2 сая, соёлын төв 0.1 сая төгрөг.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Булган сумын ИТХ-ын 2020 оны төсвийг батлах тухай 12/05 дугаар хуралдааны тогтоолд сумын ЗДТГ, сум дундын ойн анги 40.8 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 45.4 сая төгрөгийг орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 4.6 сая төгрөгөөр буюу 111.3 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
			Зөрүү	Хувь
Сум дундын ойн анги	12.0	20.5	8.5	170.8
ЗДТГ	28.8	24.9	3.9	86.5
ДҮН	40.8	45.4	4.6	111.3
Сум дундын ойн ангийн талбай тусгаарлалт	12.0	20.5	8.5	170.8
ЗДТГазрын байранд үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудын гэрэл цахилгаан, халаалт, цэвэр бохир усны төлбөр	28.8	24.9	3.9	86.5
ДҮН	40.8	45.4	4.6	111.3

Эх сурвалж: Булган сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын ЗДТГ-ын орлого тасарсан нь ЗДТГ-ын байранд үйл ажиллагаа явуулдаг Улсын бүртгэлийн хэлтэс, Прокурорын газар, Шүүх шинжилгээний албаны халаалтын зардал хэмнэгдсэн, ковид-9 холбоотойгоор аймгийн баяр наадам үед үйлчилгээний цэгийн зөвшөөрөл бага олгогдсон зэргээс шалтгаалсан байна. Харин сум дундын ойн ангийн орлого давсан нь өмнөх оны талбайн тусгаарлалтын мөнгийг авлагаар бүртгээгүйг бүртгэж төвлөрүүлсэнээс шалтгаалсан байна.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 11,136.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 11,136.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 12.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 11,148.0 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь сумын ИТХ-ын ГХУСАЗЗ-ийн зардлыг 12.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 11,148.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 11,148.1 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,345.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 8,460.2 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлэгээр, 1,448.9 сая төгрөгийг ТЗШ-ийн байгууллагуудын орон

нутгийн төсвөөс санхүүжих байр ашиглалттай холбоотой зардал, 40.8 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,535.9 сая, тусгай зориулалтын шилжүүлэгээс 7,906.8 сая төгрөгийг санхүүжүүлэн, 258.9 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 45.4 сая төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 4.6 сая төгрөгөөр давсан нь сум дундын ойн ангийн талбай тусгаарлалтын орлого, шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 10,017.1 мянган төгрөг буюу 88.7 хувьтай байгаа нь өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажилласан, урсгал үйл ажиллагааны зардалд тэвчиж болох зардлыг санхүүжүүлээгүйгээс шалтгаалсан байна. Үүнд:

- ✚ ЕБС, цэцэрлэгүүдийн халаалтын зардлыг 0.5 сар дутуу халаасан,
- ✚ Урсгал үйл ажиллагааны зардалд тэвчиж болох зардлыг хойшлуулсан,
- ✚ Боловсролын байгууллагын хоол хүнс, үдийн цай, дотуур байрны зардал хэмнэгдсэн,

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 6.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 589.9 сая төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 8 төсөл, арга хэмжээнд 99.1 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 76.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 32.0 сая, Засаг даргын нөөц хөрөнгөөс 54.1 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 151.5 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 21.6 сая төгрөг нийт 259.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр соёлын ордонд баримтад кино бүтээхээр 30.9 сая, Засаг даргын нөөц хөрөнгөөс хог хаягдлын цэгийг булах зорилгоор 47.0 сая, ИТХ-д хэлмэгдэгсэдийн ар гэрт 0.9 сая, 3-р цэцэрлэг Эрдмийн өргөө цогцолбор сургуульд эко сургууль цэцэрлэг шалгаруулах болзолт уралдааны шагналд 1.2 сая, БСШУЯ-наас ирсэн физикийн тоног төхөөрөмжийн үнэ 5.0 сая нийт 54.1 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас байгаль орчны нөхөн сэргээлтийн зардал, БСУГ-аас ЭЕШ-д тэргүүлсэн судлагдахууны шагнал, мялзан өвчнөөр устгагдсан гахайны нөхөн олговор, статистикийн тооллого судалгааны зардал, далангийн хамгаалалтын зардал, хотын төвийн ногоон байгууламж, хог хаягдлын цэгийг дарж булшлах зардалд 151.3 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 21.6 сая төгрөг нийт 257.9 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 2292 мэдээллээс 2135 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийн хугацаа болоогүй, 141 мэдээллийг хугацаа хоцроож, 9.3 сая төгрөгийн өмч хөрөнгө захиран зарцуулах 7 мэдээллийг байршуулаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тухайлбал: Хот тохижилт үйлчилгээний анги 34, ЗДТГ 1, Цоожид өрхийн эрүүл мэндийн төв 24, Эмийн цэцэглэн өрхийн эрүүл мэндийн төв 22 мэдээлэл, соёлын төв 8, 2-р цэцэрлэг 8, 6-р цэцэрлэг 2, 7-р цэцэрлэг 1, 1-р цэцэрлэг 2, спортын сургууль 9, ОНХС, СХС 30.
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтын төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэрийг мэдээлээгүй байна. Тухайлбал: Сумын Засаг даргын 2020 оны “Хүндэтгэл үзүүлэх тухай” А/184, “Урамшуулал олгох тухай” А/198, “Хөрөнгө гаргах тухай” А/215, А/183, А/171, “Дэмжлэг үзүүлэх тухай” А/179 захирамж, ЗДТГ 1 тушаал, Цоожид өрхийн эрүүл мэндийн төв 30 тушаал.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	-	3	-	-	-	100
Нийт	3	-	3	-	-	-	100

Эх сурвалж: 2019 оны байгууллагын статитик мэдээ.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 18 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 20 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 18 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 тусгай сан түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-12, “Хязгаарлалттай”-6 /Булган сумын 2, 3, 6, 7-р цэцэрлэг, Цоожид, Эмийн цэцэглэн өрхийн ЭМТ/ дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 1,401.9 сая төгрөгийн 63 алдаа, зөрчил илрүүлснээс 3.0 сая төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 48.5 сая төгрөгийн 10 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 29.2 сая төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1,318.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 48 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 1.3 сая төгрөгийн программ хангамжийг бусад биет бус хөрөнгийн дансанд буруу тайлагнасан, үндсэн хөрөнгийн дансанд 3.1 сая төгрөгөөр барилга байгууламжийн дансанд илүү нэгтгэсэн.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад байдлаар аудитаар 1 алдаа зөрчил илэрснийг дараах байдлаас шийдвэрлэв. Үүнд:

- Харьяа байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 2292 мэдээллээс 2181 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийн хугацаа болоогүй, 95 мэдээллийг хугацаа хоцроож, 9.3 сая төгрөгийн өмч хөрөнгө захиран зарцуулах 7 мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны

цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтуудыг тохиолдсон байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтуудыг хэрэгжүүлэн мэдээллийг шийдвэрийг нөхөж байршуулан, цаашид алдаа дутагдлыг давтан гаргахгүй, таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

Төвлөрүүлэн захирагчид 1,462.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 5 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төсвийн Ерөнхийлөн захирагч төсвийн жилийн дундуур хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн жилийн төсөвтөө оруулсан өөрчлөлт, хийсэн зохицуулалтынхаа гүйцэтгэлийг нь анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнадаг байх, Харин төсвийн Төвлөрүүлэн захирагч харьяа байгууллагуудынхаа худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилтийг цаг хугацаанд нь дүгнэх асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Хууль, журмын хэрэгжилттэй холбоотой асуудал.

4.1.1 Илрүүлэлт: Сум хөгжүүлэх санд 0.1 сая төгрөгийн бараа материал, 0.7 сая төгрөгийн тавилга эд хогшил бүртгэлтэй байна. Мөн 8.9 сая төгрөгийг ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ыг зөрчин зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.1.2 Эрсдэл: Хөрөнгө эзэнгүйдэж, дутагдах эрсдэлтэй.

4.1.3 Өгсөн зөвлөмж: Сум хөгжүүлэх сангийн дансанд бүртгэлтэй байгаа хөрөнгийг картжуулан, ЗДТГ-т шилжүүлэх, дээрх журмын 1.8-д "Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна", 1.9-д "....., 1.8-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч хэрэгжүүлж ажиллах, албан тоот ирүүлсэн.

4.2 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ.

4.2.1 Илрүүлэлт: 2020 онд авлага 51.5 сая, өглөг 2.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2 дахь заалтыг хэрэгжүүлж өр, авлага үүсгэхгүй байх хуулийн шаардлагыг биелүүлээгүй байна. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2.2 Эрсдэл: өр, авлагын насжилт нэмэгдэж, эзэнгүй болох.

4.2.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн өмнөх оны өр, авлагыг барагдуулах, СХС-аас олгосон зээлийн хугацаа хэтэрсэн зээлдэгчийн асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, авлагыг бүрэн барагдуулж, төсвийг хохиролгүй болгож, зээлийн гэрээний заалтыг нарийвчлан сангийн журамтай уялдуулан шинэчлэх.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч хэрэгжүүлж ажиллах, албан тоот ирүүлсэн.

4.3 Орлоготой холбоотой асуудал.

4.3.1 Илрүүлэлт: Орлогын төлөвлөгөөг нийт дүнгээрээ 945.1 сая төгрөгөөр баталж, 936.4 сая төгрөгийг бүрдүүлэн, 8.7 сая төгрөгөөр буюу 0.9 хувиар тасалсан байна. Энэ нь хэмжилт, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 41.2.1 дэх заасан орон нутгийн төсөвт оруулах болон төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

4.3.2 Эрсдэл: Сумын төсвийн орлого бүрдэхгүй, хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлж чадахгүйгээс өглөг нэмэгдэх.

4.3.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн орлогыг бодитой төлөвлөх, орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд дайчлан ажиллах.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллах, албан тоот ирүүлсэн.

4.4 Дотоод хяналттай холбоотой асуудал.

4.4.1 Илрүүлэлт: Аудитаар нийт 1,401.9 сая төгрөгийн 63 алдаа, зөрчил илэрсэн нь үнэлгээ, Үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.4.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийг зүй зохисгүй, үр ашиггүй зарцуулагдах.

4.4.3 Өгсөн зөвлөмж: Санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах, төсвийн сахилга баттай ажиллах.

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллах, албан тоот ирүүлсэн.

4.5 хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал.

4.5.1 Илрүүлэлт: Ө нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Сангийн сайлын 2017 оны 347 тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь эрх ба үүрэг, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.5.2 Эрсдэл: Орлогыг нуун дарагдуулах, тайлагнахгүй бах.

4.5.3 Өгсөн зөвлөмж: НӨАТТ хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.3.2, 17.6 заалтуудыг мөрдөж, анхан шатны баримтыг И баримтаар бүрэн баталгаажуулж хэвших.

4.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллах, албан тоот ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

Огноо: 2021/03/25

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

Огноо: 2021/03/25

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Г.ЦЭРЭНЛХАМ

Огноо: 2021/03/25

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Булган сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Огноо: 2021.03.25 № Шалгагдсан байгууллагын нэр:	Аудитын нэр: Алдаа, зөрчлийн товч утга Булган сумын Засаг дарга	Мөнгөн дүн	Аудитын код: Аудитын байгууллагаас гз гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Сая төгрөгөөр Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Харьяа байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 2292 мэдээллээс 2181 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа болоогүй, 95 мэдээллийг хугацаа хоцроож, өмч хөрөнгө захиран зарцуулах 7 мэдээллийг байршуулаагүй байна.	9.3	Алдаа дутагдлыг давтан гаргахгүй, таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.	Засаг дарга, Санхүү албаны дарга	П.Нөхөрлөлбаяр, Ц.Бат-ирээдүй
2	Сум хөгжүүлэх санд 0.1 сая төгрөгийн бараа материал, тавилга эд хогшил бүртгэлтэй байна.	0.7	ЗДТГ-т шилжүүлэн бүртгэх зөвлөмж өгөх.	Засаг дарга, Санхүү албаны дарга	П.Нөхөрлөлбаяр, Ц.Бат-ирээдүй
3	2020 онд авлага, өглөг нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2 дахь заалтыг хэрэгжүүлэн өр, авлага үүсгэхгүй байх шаардлагыг биелүүлээгүй байна.	51.5	Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн өмнөх оны өр, авлагыг барагдуулах зөвлөмж өглөө.	Засаг дарга, Санхүү албаны дарга	П.Нөхөрлөлбаяр, Ц.Бат-ирээдүй
4	Орлогын төлөвлөгөөг 945.1 сая төгрөгөөр баталж, 936.4 сая төгрөгийг бүрдүүлэн, 0.9 хувиар тасалсан байна.	8.7	Төсвийн орлогыг бодитой төлөвлөх, орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд дайчлан ажиллах зөвлөмж өглөө.	Засаг дарга, Санхүү албаны дарга	П.Нөхөрлөлбаяр, Ц.Бат-ирээдүй
5	Аудитаар нийт 1,401.9 сая төгрөгийн 63 алдаа, зөрчил илэрсэн нь үнэлгээ, Үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.	1,401.9	Санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах, төсвийн сахилга баттай ажиллах зөвлөмж өглөө.	Засаг дарга, Санхүү албаны дарга	П.Нөхөрлөлбаяр, Ц.Бат-ирээдүй
6	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр худалдан авалт хийсэн.	-	НӨАТТ хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.3.2,17.6 заалтуудыг мөрдөж, анхан шатны баримтыг И баримтаар бүрэн баталгаажуулж хэвших зөвлөмж өглөө.	Засаг дарга, Санхүү албаны дарга	П.Нөхөрлөлбаяр, Ц.Бат-ирээдүй
	Дүн	1,472.1			